

СОНСГОЛОН БАРМАТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТОГООЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3-р сарын 16 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“СОНСГОЛОН БАРМАТ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дахь заалтууд, 2025 оны 3 дугаар сар 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Сонсголон Зам, 75 компанийн өөрийн байранд хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

- Компанийн 2025 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
- Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоох;
- Компаний үйл ажилгааны чиглэл өөрчлөгдсөний улмаас компаны дүрэмд өөрчлөлт оруулах комиссыг томилох
- дүрмийн өөрчлөлтийн төслийг хэлэлцэж батлах
- Бусад асуудал

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2025 оны 04 дугаар сарын 3-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /С.Сүхбаатар/-т гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.


7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|------------------|---------------------------------------|
| • С.Оюунцэцэг | хурлын дарга |
| • С.Сүхбаатар | хурал зохион байгуулах комиссын дарга |
| • Д.Ариунбаатар | тооллогын комиссын дарга |
| • А.Ариунсайн | гишүүн |
| • Д. Мөнх-Эрдэнэ | гишүүн |

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс даалгасугай.

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Сонсголон бармат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /С.Сүхбаатар/-т даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
СЭВЛӨЛИЙН ДАРГА

С. Оюунцэцэг

/С.ОЮУНЦЭЦЭГ/